


**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 09 өдөр


Дугаар 74

Мандалговь

Г Автомашинд үнэлгээ тогтоож,
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтооолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 14,794,445 /арван дөрвөн сая долоон зуун ерэн дөрөв мянга дөрвөн зуун дөчин тав/ төгрөгийн балансын үнэтэй 24,722,222,04 /хорин дөрвөн сая долоон зуун хорин хоёр мянга хоёр зуун хорин хоёр/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 2 ширхэг автомашины худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоон нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.
2. Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Адъяасүрэн)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.
 - 2.1 Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх;
 - 2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн
1 дугаар тогтоолын хавсралт

Орон нутгийн өмчийн газрын дуудлага худалдаагаар худалдах
тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Mark	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтаад орсон он	Тээврийн хэрэгслийн	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Худалдах үнэ
			Сер и	Дугаар			Арлын дугаар					
1	суудлын автомашин	SUZUKI	ДУА	72-72	2003	2012	HT51S806864	320,000	2,000,000	249,999.99	1,750,000,01	2,000,000
2	Жийп автомашин /суудлын/ 100	Land cruiser - 100	ДУА	28-03	2004	2014	UZJ1000150628	350,000	12,794,445	1,066,203.75	11,728,241,25	15,000,000
									14,794,445 /арван дөрвөн сая долоон зуун ерэн дөрөв мянга дөрвөн зуун дөчин тав/ төгрөг	1,316,203.74 /нэг сая гурван зуун арван зургаан мянга хоёр зуун гурав/ төгрөг	13,478,241,26 /арван гурван сая дөрвөн зуун далан найман мянга хоёр зуун дөчин нэгэн мөнгө хорин таван/ төгрөг	17,000,000 /арван долоон сая/ төгрөг
							Хөрөнгийн нийт дүн					